

5

Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай

УДИРТГАЛ 52

- | | | |
|----|--------------------------------|----|
| 1. | Бодлогын баримт бичгийн дугаар | 52 |
| 2. | Зорилго | 52 |
| 3. | Хамрах хүрээ | 53 |
| 4. | Мөрдөж эхлэх хугацаа | 53 |
| 5. | Бүрэн эрх, удирдлага | 53 |

БОДЛОГО 54

- | | | |
|----|---|----|
| 1. | Өмнөговийн нийлүүлэгч болохыг тодорхойлох Оюу Толгой ХХК-аас тавьж буй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт | 54 |
| 2. | Өмнөговийн нийлүүлэгчдийн онцлог | 54 |
| 3. | Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх | 55 |
| 4. | Тайлагнах шаардлага | 57 |

Удиртгал

1. Бодлогын баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичгийг ХААБ-06: **Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого** гэж нэрлэнэ.

2. Зорилго

Энэхүү бодлогыг үүнд тодорхойлсоны дагуу “Өмнөговийн” гэх ангилалд багтах нийлүүлэгчдэд эхний ээлжинд давуу эрх олгон, хамтран ажиллах тухай Оюу Толгой ХХК-ийн үүрэг амлалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулав.

Түүнчлэн дор дурдсан зүйлсийн талаарх ойлголтыг тодорхой болгоно. Үүнд:

- Өмнөговийн нийлүүлэгч гэх тодорхойлолтод нийцсэнийг илтгэх эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт;
- Нөөц баялгийн салбарын хэрэгцээ, шаардлагын талаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлагад үндэслэн Оюу Толгой ХХК-аас боловсруулсан Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөрүүд;
- Оюу Толгой ХХК-ийн ажилтнуудад тавигдах тайлагналын шаардлага зэрэг болно.

Энэ бодлого нь дараах давхар зорилтуудыг хэрэгжүүлэхэд Оюу Толгой ХХК-д дэмжлэг болно. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн дотоодын нийлүүлэгчид, ялангуяа уурхайн үйл ажиллагаа явуулж буй Өмнөговийн бүс нутгийн нийлүүлэгчдийг хөгжүүлэх, дэмжихтэй холбоотой үүрэг амлалтаа биелүүлэх;
2. Оюу Толгой ХХК-ийн уурхайн ашиглалтын хугацааны хэрэгцээ шаардлагыг ойролцоох бүс, орон нутгаас хангах урт хугацааны, тогтвортой, дотоодын хангамжийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх явдал юм.

Зураг 1-д харуулснаар ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлого нь Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах үндсэн найман бодлогын нэг нь юм.

Зураг 1: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааг удирдан зохицуулах үндсэн бодлогын баримт бичгүүд



3. Хамрах хүрээ

Энэхүү бодлогын баримт бичгийг дараах хүмүүс даган мөрдөнө. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн бүх ажилтан;
- Өмнөговийн гэх тодорхойлолтод нийцэх бүх эрх бүхий нийлүүлэгчид (1-р Хэсэг: Өмнөговийн нийлүүлэгч болохыг тодорхойлох Оюу Толгой ХХК-аас тавьж буй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт-д заасны дагуу)

4. Мөрдөж эхлэх хугацаа

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогыг 2012 оны 11-р сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Бүрэн эрх, удирдлага

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогын баримт бичгийг Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2012 оны 11-р сарын 20-ны өдөр батлав.

Энэхүү баримт бичгийг жил бүр эсхүл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянан засварлана.

Оюу Толгой ХХК-ийн Хангамж, Дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хариуцна. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах аливаа санал хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах бөгөөд тэрээр зохих ёсоор хянан, батална.

Бодлого

1. Өмнөговийн нийлүүлэгч болохыг тодорхойлох Оюу Толгой ХХК-аас тавьж буй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт

Энэхүү бодлогын хүрээнд Өмнөговийн нийлүүлэгч гэж доорх шаардлагыг хангасан Үндэсний нийлүүлэгчийг хэлнэ.

- Өмнөговь аймагт бүртгэлтэй байх;
- Тус аймагт бараа үйлдвэрлэдэг эсвэл нийлүүлдэг, эсвэл үйлчилгээ үзүүлдэг,
- Нийт үндсэн ажилтнуудын 75-аас дээш хувь нь Өмнөговь аймагт амьдарч ажилладаг Монгол улсын иргэд байх,
- Оюу Толгой ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж буй тухайн байгууллагын төв эсхүл салбар нь Өмнөговь аймагт бүртгэгдсэн байх;

Дээрх тодорхойлолтод хамаарах нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-аас хэрэгжүүлэх дор дурдсан бодлогын хүрээнд зохих байдлаар боломж хүртэх, дэмжлэг авах хөтөлбөрт хамрагдах эрх бүхий байна.

2. Өмнөговийн нийлүүлэгчдийн онцлог

Одоогийн байдлаар Өмнөговийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй нийлүүлэгчдийн хувьд уул уурхайн салбарын шаардлагын талаарх ойлголт хангалтгүй байгаа бөгөөд энэ нь Оюу Толгой ХХК-ийн шаардлагын дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад амжилттай оролцоход нь тодорхой хэмжээнд саад болж байгаа тал олон жишээгээр харагдаж байна.

Өмнөговийн нийлүүлэгчдийг эн тэргүүнд авч үзэх, эрчимтэй хөгжиж байгаа уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарын зайлшгүй шаардлага, стандартыг хангаж ажиллах чадвартай болоход нь туслах зорилгоор Оюу Толгой ХХК-ийн зүгээс зорилтот боломжуудаар дэмжих талаар энэхүү бодлогод тусгаж өгсөн болно.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд, уг бодлогоор Өмнөговийн нийлүүлэгчдэд давуу эрх олгож буй нь зүй зохистой дэмжлэг, түлхэц үзүүлж буй эсэхийг тодотгох үүднээс Оюу Толгой ХХК-аас Өмнөговийн нийлүүлэгчдийн онцлог байдал, тэдэнд тулгардаг бэрхшээлийн талаар тодорхойлсон болно.

Өмнөговийн нийлүүлэгчид нь ихэвчлэн:

- Нэгжийн үнэ өртөг багатай бүтээгдэхүүн / үйлчилгээ үйлдвэрлэгчид байдаг;

- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээс илүүтэйгээр үйлчилгээ үзүүлэх нийлүүлэгчид давамгайлдаг;
- Хангамжийн сүлжээний удирдлага, бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр туршлага багатай бөгөөд хязгаарлагдмал боломжтой;
- Бэлэн мөнгөний эргэлтийн хязгаарлалтад орсон, өрсөлдөх чадвартай үндсэн хөрөнгө дутагдалтай;
- Төлбөрийн нэхэмжлэхийн бичиг баримтын боловсруулалт, зөв зохиистой бэлтгэх талаар мэдлэг багатай;
- Шаардлагатай хэмжээний үйлчилгээ үзүүлэх чадвар бага (заасан хугацаанд), үйлдвэрлэлд хэрэглэж байгаа арга технологи, хүчин чадал нь хязгаарлагдмал;
- Уул уурхайн салбарын нарийн төвөгтэй бөгөөд давтагдах шинж бүхий өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үйл явцын талаар ойлголтгүй;
- Гэрээний нөхцөл, болзлын дагуу ажиллахаасаа илүүтэй дан ганц худалдан авах захиалга дээр үндэслэн эсхүл албан бус хэлбэрээр ажил хэрэг явуулдаг;
- Тендерийн баримт бичигт заасан Ажлын хамрах хүрээ/Техникийн нөхцөл болон төслийн талбай дахь эцсийн хэрэглэгчдийн эрэлт, шаардлагыг бүрэн биелүүлэх бололцоогүй;
- Уул уурхайн салбарын стандарт, шаардлагыг хангахад хэрэглэгддэг чанарын баталгаажуулах систем, тавигддаг шаардлагын талаар туршлагагүй;
- Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагаа, ялангуяа уурхайн үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт, хангамжийн талаар мэдлэг хомс бөгөөд энэ байдал нь тухайн бүс нутаг дахь уг эрэлт хэрэгцээнээс үр өгөөж хүртэх хэмжээнд бизнесээ зөв, зорилготой хөгжүүлэх, цаг хугацаанд нь оновчтой удирдах чадваргүй;
- Худалдан авалт, хангамжийн сүлжээний хувьд импортоор оруулж ирсэн бараа бүтээгдэхүүнийн өрсөлдөх чадварын нийт зардлын тооцоог харьцуулан нотлох боломжгүй;
- Өрсөлдөөнд амжилттай оролцоход нь бичиг хэрэг, материалын орчуулга зэргээр гадаад хэлний туслалцаа шаардлагатай байдаг онцлогтой.

3. Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх

Оюу Толгой ХХК нь Өмнөговийн гэх тодорхойлолтод нийцсэн нийлүүлэгчдийн хөгжлийг дэмжих, чадавхижуулах зорилгоор тэдэнд чиглэсэн дэмжлэг бүхий нилээд олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Өмнөговийн нийлүүлэгчдэд тусгайлан зориулсан хэд хэдэн арга хэмжээг дор харууллаа. Өмнөговийн нийлүүлэгчид хамрагдах боломжтой ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлого-д тусгагдсан хөтөлбөрүүд дээр эдгээр арга хэмжээг нэмж хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Даланзадгад дахь Бизнес хөгжлийн төв: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагаанд шаардагдах өндөр стандарт, цаашилбал Монголын зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангах чадвартай нийлүүлэгч болж хөгжихөд нь туслах зорилгоор Өмнөговийн аж ахуйн нэгжүүдэд

- сургалт, зөвлөгөө, бизнес хөгжлийн тусламж үзүүлэх төв.
2. Бичил зээлийн хөтөлбөр: Жижиг дунд бизнес эрхлэгч шинэ аж ахуйн нэгжүүдийг зах зээлд гарч ирэхэд нь туслах, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх замаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны хамрах хүрээ, далайцыг өргөжүүлэн тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Өмнөговийн нийлүүлэгчдэд бичил зээл олгох хөтөлбөр.
 3. Үнийн урамшуулал: худалдан авах бүтээгдэхүүн / үйлчилгээний төрөл, нийлүүлэгчдийг хөгжүүлэхэд баримталж буй стратеги, бодлогоос хамааран 5%-аас 20% хүртэл үнийн урамшуулал олгохыг зөвшөөрнө. Үнийн урамшууллын уг зөвшөөрлийг Оюу Толгой ХХК-ийн удирдлагаас батлах ба зарцуулалтын буюу худалдан авалтын төрлөөс нь хамааруулан жилээр тогтоож, Оюу Толгой ХХК-ийн холбогдох цахим хуудсанд мэдээлнэ.
 4. Худалдан авалтын зорилтот төрөл: Оюу Толгой ХХК-аас Өмнөговь аймгаас авах бүтээгдэхүүн, үйлчилгээний зорилтот төрлийг тодорхойлно. Зорилтот төрлийн талаарх бүх мэдээллийг олон нийтэд жил бүр мэдээлж, Оюу Толгой ХХК-ийн цахим хуудасны худалдан авах ажиллагаатай холбогдох хэсэгт байршуулна. Өрсөлдөөнийг илүү өрнүүлэх үүднээс Өмнөговийн нийлүүлэгчдээс авах тухайн зорилтот төрлийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нь нийт худалдан авалтын 80%-аас хэтрэх ёсгүй болно.
 5. Төлбөрийн нөхцлийг шинэчлэх, тохируулах: Оюу Толгой ХХК Өмнөговийн нийлүүлэгчдэд зориулан (явцын төлбөрийн хуваарь, заасан хугацаанд тохиролцсоны дагуу бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг хүргэж чадсан эсэхтэй уялдуулан) төлбөрийн хуваарьт тохируулга хийнэ.
 6. Давуу эрхтэй нийлүүлэгч – хоёр болон түүнээс дээш тооны санал / тендер техникийн хувьд буюу тендерийн баримт бичгийн бүх шаардлагыг хангасан ба хоорондоо үнийн зөрүү нь харьцангуй бага, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны шаардлагуудыг хангаж чадахуйц байгаа бол Өмнөговийн нийлүүлэгчид үндэсний болон гадаадын нийлүүлэгчдээс илүүтэй давуу эрх олгон, сонгоно.
 7. Үнийн санал өөрчлөх эрх – Дараах нөхцөлд Өмнөговийн нийлүүлэгчдэд тендерийн үнийн саналаа дахин авч үзэх боломж олгоно. Үүнд:
 - \$100,000 ам.доллараас дээш дүнтэй тендерт оролцож байгаа тохиолдолд;
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь техникийн шаардлага хангаж байгаа тохиолдолд;
 - Өмнөговийн нийлүүлэгчийн үнийн санал ба үндэсний, гадаадын нийлүүлэгчдийн санал болгосон тендерийн үнийн саналын зөрүү нь 10% дотор байгаа тохиолдолд боломжтой болно.

4. Тайлагнах шаардлага

Оюу Толгой ХХК нь гол сонирхлын бүлгийн талуудад үйл ажиллагааны талаар тайлагнах, гүйцэтгэлийн удирдлагын горимыг баримтлан ажиллах үүрэгтэй бөгөөд энэ нь мөн үүгээр үл хязгаарлагдана:

- Удирдлагад сар бүр тайлагнах;
- ТУЗ-д улирал тутам тайлагнах;
- Жил бүр дотоод аудит хийлгэх.

Тайланд хамгийн багадаа дор дурдсан мэдээллийг заавал тусгах бөгөөд энэ нь мөн үүгээр үл хязгаарлагдана. Үүнд:

- Зарцуулалтын буюу Худалдан авалтын дүн, төрлөөр;
- Өмнөговийн нийлүүлэгчид ба үндэсний болон гадаадын нийлүүлэгчдийн хийсэн худалдан авалт, хувиар;
- Зорилтыг бодит гүйцэтгэлтэй харьцуулсан байдал зэрэг болно.

